

Жан Сам Хён

БНСУ.Кенвон Их Сургуулийн
профессор, доктор Ph.DХУА СО-ГИЙН ЧОГСА ВИЖОН ОНОЛ,
ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Түлхүүр үг: Үндэсний ухамсар, ард олон, тэгш эрх, таван ёс, буруу номлол.

Товч утга: Энэхүү өгүүлэлд шинэ үеийн Солонгосын нэрт гүн ухаантан Хуа Со-гийн Солонгосын тусгаар тогтнолд үндэсний ухамсрын гүйцэтгэх үүргийн тухай онол болох Чогса вижон онол, түүний онцлогийг тухайн үеийн нөхцөл байдалтай холбон тайлбарлав. Мөн Чогса вижон буюу Хуа Со-гийн харийг үл халдаах, дотоодоо тохинуулах үзэл нь улс төр, эдийн засаг, соёл, цэрэг армийн хувьд бие даан орших үндэсний үзэл болох талаар авч үзнэ.

Чогса Вижон үзлийн зүй зохистой шинж. Энэхүү үзэл нь өрнийг болон Японыг эсэргүүцэх, Японы эсрэг журамт цэргийн хөдөлгөөний галыг бадраасан Хуа Со урсгалын төлөөлөгчид буюу Гим Пён Мүг, Юү Жүн Гюу, Паг Мүн Ил, Чвэ Иг Хён, Юү Ин Сог нарын чогса үзэл санаанаас эхтэй. Эхлээд Хуа Со-гийн чогса үзэл баримтлалын талаар авч үзье. Хуа Со-гийн чогса үзэл баримтлал уламжлалт Күнзийн сургаалын "Чогса Вижон" буюу "бурууг няцааж, зөвийг бадраах" гэсэн үзлээс эхтэй. Тэгвэл "Чогса Вижон" гэдэгт зөв гэж юу, буруу гэж юу вэ? *Хуа Со-гийн хувьд "Чогса вижон" гэдэг нь буруу ухаан болох будда, дао, югванхаг, сохаг эрдэм, үзэл санааг зайлуулж, зөв ухаан болон Күнз, Мэнз, Сүнз, Жүз нарын эрдэм, үзэл санааг өмгөөлж тэрхүү уламжлалыг хадгалья гэсэн үзэл байв.*

Хуа Со "Энэ хорвоогийн дөрвөн ёс зүй (энэрэл, ёс, журам, ухаан) бол тэнгэрийн ёсны үнэн мөн, урхун (таван ёс) хүний ёсны дээд. Үүнээс бусад нь бүгд гаж урсгал, буруу номлол гэжээ. Жү-зийн ухаанд нэвтэрч 500 жил болсон Жусоны хувьд, номын хүмүүсийн сэтгэлээр бол зөв нь зайлшгүй уламжлалт Күнзийн ухаан, буруу нь уламжлалт Күнзийн ухаанд хүч соригч Сохаг гэж үзэж болно. Хуа Со-гийн эх орондоо санаа зовинох байр сууринаас үзвэл, буруу номлол түгэж байгаа нь улирлын шинжит өвчтэй адилхан учир зайлах аргагүй. Сохаг-ийг буруу ухаан гэж үзэж, өрнийнхнийг адгуус гэж ухаарах шалтгаан нь сохаг болон өрнийнхний номлож байгаа зүйлс Күнзийнхтэй эсрэгцэн хүлээн зөвшөөрөх аргагүй байдагт оршино. Үүнд:

1. Их туйл түмэн бодисын эх үндэс болохыг мэдэж чадахгүй байх¹;
2. Бурхан (их туйлын ёс) биш тэнгэрийн эзэнд итгэх;
3. Гурван зүйл ичгүүр (хүн хаан, эцэг эх, ад чөтгөрт мөргөж болохгүй);
4. Өвөг дээдэстээ тахил өргөлгүй тахилын өргөөнд залагдагсдыг шүтэх;

¹ И Хан Ну Хуа Со-гийн эмхтгэл. Тэ Янь хэвлэлийн газар. 1975. 383-397 дахь тал

5. Эцэггүй хаангүй болохоор хаан түшмэл, дээд доод, эцэг хүүгийн ялгаа байхгүй байх;
6. Биеэ өргөж энэрэнгүйг бүтээх биш, үхлийг мөнхийн амь гэж баясах;
7. Өнгөнд шунаж, эр эмийн ялгаварт ёсгүй болох;
8. Мөнгөнд шунах;
9. Өрнийн хүний хийсэн зүйл хачин жигтэй байх;
10. Диваажин тамын номлолоор орлогын аравны нэг хувийг авч, ардын сэтгэлийг урвуулах эдгээр болно.

Эдгээр агуулга Жүзийн ухааныг баримтлагч Жусоны уламжлалт ёс суртахуунтай эрс тэс ялгагдаж байна. Хуа Со-гийн бодлоор "Дэлхийд хосгүй таван зүй, таван ёсыг эзэн хаандын төр үйлдсэн, ариун билэгтнүүдийн сургаал энэ ёсыг тодруулсан" атал, үүнтэй эсрэгцсэн нь гаж урсгал, буруу номлол байхаас өөр аргагүй байжээ. Тэгвэл сохаг хүртэл Күнзийн сургаалтай шууд эсрэгцсэн гаж урсгал, буруу номлол мөн. Хуа Со-гийн үзснээр өрнийн дайсан өнгөндөө сохаг-т итгэдэг хүмүүсийг нэвтрүүлж, эрч хүч авахуулж байгаа боловч, тэдний далд санаа нь Жусончуудын дунд өөрсдийн гар хөл бологчийг болгож, Жусоны сул тал, бодит байдлыг тагнаж туршин уламжлалт соёлыг устгах, хүн амьтан эд зүйлийг булаан эзэлж, эцэстээ нутаг дэвсгэрийг байлдан эзлэх гэсэн санаархал нуугдаж байна. Хуа Со гаж урсгал, буруу номлолыг зайлуулах, эх орноо худалдагч түшмэлийг устгах нь "Хавар Намар" судрын хууль, ариун билэгтнүүдийн сургаал тул зөв зохистой гэж үзжээ.

Күнз, Жүз, Сунз нарыг залгамжилсан Хуа Со-гийн сохаг ба гадаадын гүрнүүдийн эзэрхийллийн тухай зөв ухамсарт үндэслэн гаргасан *Чогса Вижон үзэл санааг үндэсний ухамсрын илрэл гэж үнэлж болно. Хуа Со-гийн сэтгэлийг хамгийн их зовоож байсан нь өрнийн номлол Жусоны язгуур ухааныг сүйрүүлж, хүн төрөлхтнийг адгуус мэт болгож орхих вий гэсэн бодол байв. Олон улсын байдал хүртэл өөрчлөгдөж, Жусонд нэгэнт 200 жил төрийн нөлөөлөлөө хэрэгжүүлж байсан Чин улс хүртэл өрнийн өмнө бууж өгчихөөд байсан юм.*

Түүнчлэн Мин улс мөхсөнөөс хойш Дундад улсын судал Бага Дундад улс болсон Жусонд л арай гэж үлдээд байсан бөгөөд, үүнийг хадгалах нь юу юунаас ч илүү чухал шаардлагатай хэрэг болоод байна. Гэвч аль нэг улстай хамтарна гэсэн үг Хуа Со-гийн ямар ч номонд байхгүй. Тийм учраас Хуа Со-гийн бодит байдлын ухамсар, хариулах зүй урьдын "Дундадыг өргөж, харийг дарах үзэл"-д суурилж байгаа боловч, түүний зохистой шинжийг хүлээн зөвшөөрөхгүй байх аргагүй. Яагаад гэвэл Дорнын ёс суртахууны, уламжлалт соёл иргэншил цор ганц Жусонд л хадгалагдан үлдээд байсан юм. Тиймээс Хуа Со-гийн хэлсэн дотоодыг тохинуулж, харийг үл халдаах үзэл явцуу утгаар үндэсний өөрөө орших ухамсрын дотор бодит байдлыг давж гарахын төлөөх гэж хэлж болох боловч, цаашилбал, өргөн утгаар Дорнын ёс суртахууны соёл иргэншлийг хамгаалах гэсэн санаанаас гарсан гэдгийг анхаарах нь чухал юм.

Харийг үл халдаах үзэл ба үндэсний ухамсрын асуудал. Хуа Со-гийн улс оронд бодитоор тулгарсан аюулт байдлыг давж гарахын төлөө

харийг үл халдаах үзэл нь өөрөө оршихын төлөөх дөрвөн том ухамсар гэж үзэж болно. Үүнд:

Нэгдүгээрт, Хуа Со-гийн харийг үл халдаах үзэл нь улс төрийн хувьд улс үндэстэн бие даах үзэл мөн. Улс орныг захирахад бие даасан оюун санаа үндэстний амьд орших эрх, тусгаар улсын бүрэн эрхийг хадгалангаа түүхийг хөгжүүлж ирсэн гол хүчин зүйл гэж болно. Улс орон харийн хүчний улмаас бие даасан эрхээ алдвал харьяат улсаас ялгарахгүй болно. Тэр тусмаа удирдах үйлдлийн хувьд харийн хүчний шахалт дарамтанд орох буюу шууд оролцоонд автвал энэ нь тусгаар бүрэн эрхт улс гэж хэлэхэд бэрхтэй.

Жусон улс Чол Жун-гийн үед буруу номлол (католик)-ыг шахаж хорихоо сулруулсан. Тиймээс итгэгчдийн тоо асар хурдан нэмэгдсэн. Жусоны уламжлалт үзэл буюу Күнзийг дагагчдын санаа зовнисон дуу хоолой чангарсаар атал, зүгээр хараад суухын аргагүй төр удирдагчийн байр сууринд байв. Тэгвэл Дэвонгүн 1866 онд католик шашинтныг хорьж шахах зарлиг буулгаж, хэдэн сарын турш есөн франц миссионер, мөн Нам Жун Сам, Жон Ёибэ нарыг цаазлав.

Энэ үед Ридэл ламтан оргож, Хятадын Тянжинд сууж, францын алс дорнод хөлөг онгоцны цэргийн жанжин Роуз (Rose)-д байдлыг мэдэгджээ. Бээжинд сууж байсан Францын орлох төлөөлөгч Бэллонэ (Bellone) уг мэдээллийг авч, Жусоныг байлдан дагуулья гэсэн шийдээ тушаалаар гаргав. 1866 онд Францын Роуз жанжин цэргийн 3 хөлөг онгоцыг удирдаж, Ридал ламтан болон гурван Жусон итгэгч хүнээр газарчлуулж, Инчон-ы урдуур Чнхважин ба Сөүлийн Мапу Соган хүртэл орж ирэв. Үүний улмаас Сөүл айдас, самуунд автав. Энэ нь үнэндээ Жусоны газар нутгийг довтолж, улс төрийн бие даасан эрхийг заналхийлж, дотоод хэрэгт оролцсон явдал байв.

Энэ үед Жусоны төрд эвийг байгуулах, дайтан хамгаалах санал хуваагдаад байв. Ян Хон Сү Ганхва арал руу хөдлөхийнхөө өмнө хэдэн зүйл санал болгосон бөгөөд тэдгээрийн дотор түүний багш И Хан Ну-гийн саналыг хүлээн авах зэрэг санал орсон байна. Жусоны төрөөс И Хан Ну-г дуудаж ирүүлээд, зүүн хэсгийн албанд тохоосон боловч Хуа Со татгалзаж, дайтан эсэргүүцэх үзлийг онцлов. Энэ нь зөвшөөрөгдөж, төрийг нэгтгэн эцэстээ францын хөлөг онгоцны довтолгоог няцааж чадсан юм.

XIX зууны өрнөдийн гүрнүүд аль хэдийн үйлдвэрлэлийн хувьсгалд амжилт олж худалдаа үйлдвэрлэлийг дэмжих ёсонд үндэслэсэн колоницлолын бодлогоо өргөтгөж байв. Англи, франц, испани, португал зэрэг улс тэдгээрийг төлөөлж байв. Энэ үед 1842 онд Хятад улс Хар тамхины дайны улмаас Англитай шударга бус гэрээ байгуулж, Хонконгийг шилжүүлэн өгчээ. Түрүүн дурдсанчлан өрнийн улсууд эдийн засгийн хувьд Дорныг олон арван удаа халдан довтолсон нь төрийн гаднах хүч Хуа Со (И Хан Ну)-д аюулын ухамсрыг төрүүлэхгүй байх аргагүй байжээ.

Мин улсын Жусоны бие даах эрхийг баталгаажуулж байв. Харин 200 жилийн турш Жусонтой эзэн харьяатын харилцааг хадгалсан Чин улс эдийн засгийн хувьд Жусоны бие даах эрхийг уландаа гишгэсэн юм. Хуа Со-гийн үзснээр өнөөгийн өрнөд нь Чин улсаас ч дор хатуу байв. Тийм учраас

өрнөдийн түрэмгийлэл бие даах эрхийг алдахаар зогсохгүй нутаг дэвсгэрээ булаалгаж, Солонгос үндэстэн доройтох аюулыг авчрах нь зайлшгүй байв¹. Хуа Со сохаг (католик) бол гаж урсгал, буруу номлол бөгөөд түүнийг гарцаагүй няцаах ёстой боловч, сохагчуудын эдийн довтолгоо бас улс орныг мөхөлд хүргэхээр барахгүй, ард түмний амь насыг уландаа гишгэсэн учир заавал таслан зогсоох хэрэгтэй хэмээн үзсэн байна. Тийм учраас Хуа Со-гийн Чогса Вижон үзэл өрнийн цохилт гэсэн аюулын ухамсрын дотор улсын эрхийг хамгаалж, төрийн бие даасан байдлыг хэвээр үлдээх гэсэн өөрөө орших ухамсрын илрэл хэмээн үзэж болно.

Хоёрдугаар, Хуа Со-гийн харийг үл халдаах үзэл нь эдийн засгийн тусгаар тогтнолын үзэл мөн. XIX зууны өрнийн эзэнт улсын худалдааны шаардлага улс хоорондын харилцан туслах худалдаа биш, эдийн хүчээр албадсан худалдаа байв. Хуа Со ийм түрэмгийллийн эсрэг Жусон улс хамгаалах худалдааны бодлогоор хариулах ёстой гэж бодож байв. Гадаадын эд зүйлийн нэр төрөл дэндүү олноос үгээр тоочиж барамгүй, тэрний дунд өрнийн эд зүйл хамгийн ноцтой. Хаан өөрөө өрнийн эд хэрэглэхийг хорьж, өрнийн хувцас, сав суулгыг хэрэглэлгүй, байгаа бүхнийг нь хураан шатааж үлгэр үзүүлбэл гадаад дотоодод өрнийн эд зүйл ашиггүй болж, худалдаа байхгүй болно гэжээ. Хуа Со-гийн үзснээр олон төрлийн өрнийн бараа орж ирж байгаа боловч бүгд хачин жигтэй, садар самуун эд зүйлс байна. Тийм болохоор тэрээр тэдгээрийг хүний өдөр тутмын амьдралд нэмэр болох нь бүү хэл ихээхэн хор уршиг тарина гэж боджээ. Өрнийн эд зүйл орж ирэхийг хориглоё гэвэл улсын хаан гар бие оролцон үлгэр үзүүлэх ёстой гэж эдийн засгийн хувьд дотооддоо тохинох үзлийг баримталсан² нь чухал санаа мөн.

Хуа Со улаан бар жилийн 10 сарын 3-нд дахин өргөсөн айлтгалдаа эдийн засгийн учир зүйг илүү нарийн гарган харуулсан байдаг³. Үүнд:

1. Өрнийн эд зүйлийг, тухайлбал, тэд алба гувчуурын ёсыг баримталж, албан ёсоор худалдаа хийдэг байлаа ч гэсэн авах учиргүй гэсэн үг. Энэ нь өрнийн худалдааг дорнын уламжлалт алба гувчуурын хариуц гэсэн нөхөрсөг харилцааны хэлбэрээс авч үзсэн хэрэг бөгөөд, үүнийг Сугун тайбуу-гийн "Харь улсын эд барааг үл ойшоох онол"-д дөхөж байна гэж үзэж болно. Энэ нь улс төрийн учир зүй бөгөөд XIX зууны Жусоны өрнөтэй харьцах нөхөрсөг харилцаанаас нэлээд бодит байдалд ойртсон оновчтой онолын үндэс гэж болох юм.

2. Өрнөдтэй хийх худалдаа нь бидний хувцас хунар, хоол унд, орон байр гэсэн үндсэн хэрэглээний зүйлсийн нөөцийг хоосруулж байна гэж онцолсон. Энэ нь өрнөдтэй худалдаа хийснээр бий болох үндэсний хохирлыг эдийн засгийн учир зүйгээр авч үзсэн хэрэг мөн.

3. Өрнөдтэй худалдаа хийх тохиолдолд хоёр талын үйлдвэрлэх чадварын харьцаагаар дамжуулж эдийн засгийн хохирлын учир зүйн

¹ И Хан Ну Хуа Со-гийн эмхтгэл. Тэ Янь хэвлэлийн газар. 1975, 398 дахь тал

² И Хан Ну Хуа Со-гийн бүрэн эмхтгэл. 1986, 91-92 дахь тал

³ И Хан Ну Хуа Со-гийн бүрэн эмхтгэл. 1986

үүднээс хэлж, тэр худалдааны ёс бус шинжийг оновчтой оношилж байна. Өөрөөр хэлбэл, тэдний эд зүйл хүний гараар тухай бүрт бүтээгддэг байхад, бидний эд зүйл газраас гарах жилд ганц удаа хураах тариалангийн эд зүйл учир дутагдахаас өөр аргагүй гэсэн. Энэ дутагдаж байгаа тариалангийн эд зүйлийг илүүдээд байгаа өрнийн үйлдвэрийн зүйлээр арилжихад хүрвэл бид гарцаагүй ядуурч хоосорно. Тийм учраас ийм худалдаа эцсийн дүнд биднийг хохиролд оруулж, өдөр тутмын хэрэглээний барааг тансаг хэрэглээний бараагаар солих нь эдийн засгийн харилцааны хэмжээг зайлшгүй эзэн харьяатын харилцаатай болгоно гээд өрнөдтэй худалдаа хийхийг эсэргүүцсэн байдаг.

Хуа Со-гийн дээрх үзэл бодол XIX зууны Жусоны нөхцөл байдалд эдийн засгийн хувьд эрх ашгийн харилцааг маш зөв ухаж ойлгосон учир боломжтой байжээ. Эндээс бид тухайн үед үүнийг ухаж ойлгож чадсан Чогса үзэлтнүүдийн бие даасан ухамсар, бодит байдлын талаарх хурц харааг өндөр үнэлүүштэй. Энэ нь Хуа Со-гийн Чогса үзэл санаанд зүгээр нэг хуучныг өмөөрөх уламжлалт оюун санаа гэж үзэж боломгүй, эдийн засгийн нарийн ухаан байсныг харуулж байна. Энэ бол Хуа Со Солонгост халдан нэвтэрч байгаа шинэ үеийн өрнийн улсуудын тэлэх бодлогод хамгаалах гадаад худалдааны бодлогоор хариулж эсэргүүцэх гэсэн эдийн засгийн тусгаар тогтнолын үзэл санааны илрэл байсан юм гэж үзэж байна.

Гуравдугаарт. Хуа Со-гийн харийг үл халдаах үзэл нь соёлын хувьд бие даан орших үзэл байв. Жусоны сүүл үе буюу XIX зууны ёс зүйн ухааныг бат хадгалж, голлон удирдаж байсан Хуа Со уламжлалт Күнзийн сургаалын үнэ цэнэ, эмх журмыг сахин хамгаалахад бүх талаар чармайсан юм. Түүний хувьд Шилхаг гарч ирсэн, Соха-гийн уламжлал, Дунхаг-ийн үүссэн нь ёс зүйн ухааны доройтлыг илтгэж байв. Гэвч Хуа Со үүний эсрэг ёс зүйн ухаан (уламжлалт Күнзийн сургаал)-ыг тууштай хамгаалсан. Түүний хувьд Күнзийн сургаалын "ёс зүй" хорвоод хосгүй, эзэн хаадын (Ёо, Сүн, Тан, Мүн) төр бас энэхүү "ёс зүй"-г дагасан хэрэг бөгөөд ариун билэгтэн (Күнз, Мэнз, Жонз, Жүз, Сунз) нарын сургаал бас энэхүү "ёс зүй"-г тодруулсан. Тийм учраас энэхүү ёс зүйн сургаалыг хорьж, үгийг хоригч хүмүүс гаж урсгал, буруу номтон болох нь гарцаагүй. Ийм байр сууринаас авч үзвэл урван тэрсэлсэн түшмэлийг устгаж, буруу номлолыг зайлуулах нь бүгд тэнгэрийн өмнөөс гүйцэлдүүлж байгаа шударга үйл мөн.

Хуа Со Мин улсаас хойш Жусоны номын хүмүүс Жүз-ийн ухаанд л итгэж, ёс зүй болох ёс суртахуун, энэрэл журам ба үнэн тэнгэрээс эхтэй бөгөөд өөрчлөгдөх учиргүйг мэдэж, эрдэм номын үүд хаалга, зам мөрийг зөв зүйтэй байгуулж, тэрхүү уламжлалыг дагадаг байсан бөгөөд, тэгснээрээ Жусоны номын хүмүүсийн буянт үйл, баяр, зан үйл, ном бичиг хятадынхаас дутахааргүй болсон байжээ. Энэ талаар тэрээр өгүүлэхдээ: "Бурхан (туйл) сүнснээс гардаг бөгөөд сүнс нь дорно билээ. Энэрэл сайны ах бөгөөд хавар дөрвөн улирлын тэргүүн болж, нугалаат дуу таван авианы дунд байж, өвс ногоо буюу бүх үр тариа, үр жимс нь унавал түүний амь заавал соёонд найддаг бөгөөд өөрөөр хэлбэл энэ нь энэрэл билээ. Үүнээс улбаалж үзвэл, тэнгэр газрын зүүн зүг гурван зүгийн ахмад нь болж эхлэл ч, төгсгөл ч түүнд найдахыг мэдэж болно. Жү улсын эцэс үеийн ёс хөгжим зүүн Лу (Күнзийн

улс)-д байсан бөгөөд Мин улсын эцэс үед баяр буюу ёс зүйн ухаан Жусонд байсан нь үүнтэй ижил билээ" гэжээ.

Эндээс Хуа Со дорно буюу Жусон бурханы гарч ирэх сүнсний хотын энэрэл "хавар, намар"-тэй дүйх гол цөм бөгөөд Мин улсын эцэс үед улирал, ёс зүйн ухаан Жусонд байсан гэж үзэж, Солонгос үндэстний Дорнын Жусон аймгийн эх, төгсгөлийг хариуцагч энэрэлийн ариун талбар гэж бахархаж байна. Тийм учраас Жусон улс Гуре улсын үеэс эхлэн бага багаар бүдүүлгээс дундад улс болж өөрчлөгдсөн нь үнэн бөгөөд Хятад (Мин) мөхөж, өрнийн бүдүүлэг самуун өдөөж байгаа энэ үед бас Жусон ёс журмыг сахиж, хүний ёс суртахууны хамгийн сүүлийн голомт болсон гэж үзсэн байна. Энэ нь Мин улс нэгэнт мөхсөн боловч Дундад улсын соёл болох ёс зүйн ухаан Жусонд байгаа нь үндэсний ухамсарт үндэслэсэн Бага Дундад улсын хувьд бахархах сэтгэлээс гарсан үг гэлтэй. Энэ талаар: "Өрнийн хүмүүс ёсыг самууруулж байгаа нь хамгаас илүү сэтгэл зовооно. Тэнгэр газрын завсар нэг судал сайн ёс манай улсад хадгалагдан үлдээд байхад, хэрвээ түүнийг хүртэл сүйтгүүлэхэд хүрвэл тэнгэрийн таалалд нийцэх учиргүй, бид зайлшгүй тэнгэр газрын төлөө сэтгэлийг барьж, энэхүү ёсыг тодруулахын тулд мэрийж, түймэр унтраах мэт байх ёстой. Улс мөхөх сэхэх нь харин түүний дараа болно"¹ хэмээн тэрээр бичсэн байдаг. Ийнхүү Хуа Со ёс зүйн судас Жусоны хувьд хадгалаад байгаа атал үүнийг хамгаалах нь юу юунаас ч илүү яаралтай гэжээ. Тийм учраас Жусон өрнийн дайсныг хориглож чадахгүй бол Жусон төдийгүй бүх дэлхийн хүн төрөлхтөн ёс суртахуунгүй адгуус болох аюулыг тойрч чадахгүй болно гэж анхааруулсан буй.

Мөн тэрээр 1836 онд 45 насандаа "Өрнийн ухааны бурууг өгүүлэхүй" номыг бичсэн бөгөөд "өрнийн дайсан номлолоо түгээж байгаа нь ёс зүйг бүрдүүлэх гэсэн сэтгэлээс биш, тэнэг иргэдийг уруу татаж дагуулсны дараа өөрсдийн шунал хүслийг хангах гэснийх болой"¹ хэмээн үзжээ.

Түүнчлэн 1850 онд Хуа Со 59 насандаа "Манай сахих ёс журам"-ыг бий болгосон ба уг журмын 9-р зүйлийн дүгнэлтэнд "Хойд зүгийн бүдүүлгүүд хувцас өмсгөлийг сүйдэлж орхисон бол өрнийн бүдүүлгүүд сэтгэлийг идэж байна..." гээд сургаал заагч хүмүүс оюунаа чигч болгож, нүдээ том нээгээд ариун билэгтнүүдийн сургаал, өвөг дээдсийн өвийг баллаж доройтуулахгүй байх ёстой гэж христос шашныг дэлгэрүүлэхийг эсэргүүцэж байв.

200 жилийн турш Чин улсын захиргаанд байсан Жусоны үед ч Хуа Со-гийн үзэл² бодол, "Дундадыг өргөж, харийг дарах" үзэл санаа өөрчлөгдөх аргагүй байв. Тэрээр Мин улс аль хэдийн мөхөж байхгүй болсон байхад Жусоныг хөгжингүй Дундад улсын соёлын хүрээнд харьяалуулж, Мингийн мөхлөөс хойш түүний язгуур шинжийг Жусоны залгамжилж, дэлхийн түүхийн төв соёл болон хөгжих ёстой гэж үзсэн бөгөөд энэ нь өөрөө оршихын төлөөх соёлын хувьд бие даах ухамсарт түгээмэл утга оруулах түүний санааг тусгаж байна гэж болно.

¹ И Хан Ну Хуа Со-гийн бүрэн эмхтгэл. 1986. 399 дэх тал

¹ И Хан Ну Хуа Со-гийн бүрэн эмхтгэл. 1986. 10 дахь тал

² И Хан Ну Хуа Со-гийн бүрэн эмхтгэл. 1986. 171 дэх тал

Дөрөвдүгээрт, Хуа Со-гийн харийг үл халдаах үзэл нь цэргийн хувьд өөрийн хүчээр өөрийгөө хамгаалах эрмэлзэл мөн. Энд Хуа Со-гийн өрнийн хор хөнөөлийн талаарх зовнил бодитоор илэрсэн билээ. 1866 оны 9 сард Роуз жанжнаар удирдуулсан Францын хөлөг онгоц довтлон ирсэн нь улаан бар жилийн өрнийн эсрэг дайн байв. Жусоны төрд хэцүү байдлыг арилгахын тулд номын хүн Хуа Со И Хан Ну-д хэргэм зэрэг олгож дуудан ирүүлэв. Үүнд Хуа Со татгалзсан айлтгал өргөж, эвийг эсэргүүцэж, дайтаж хамгаалснаар хэцүү бэрхийг давж гарахыг санал болгов. Энэ талаар Хуа Со хэлэхдээ: "...Эдүгээ улсын үзэл эв эе, дайн тулаан хоёр хэсэгт хуваагдаад байна. Өрнийн дайсныг довтлох ёстой гэдэг нь бидний үзэл бөгөөд өрнийхөнтэй эвийг хичээх нь зүй гэж бурангуй хүмүүс үзэж байна. Харин ч дайсныг довтолбол улс орон ёс журам, ёс суртахууныг хамгаалж чадна. Хэрэв дайсантай эвийг хичээвэл хүн төрөлхтөн адгуус болох аюулд учирна. Энэ бол салаа зам, ...Дайсныг довтолж гэсэн бидний үзэл бас хоёр хуваагдаад байгаагийн нэг нь дайтаж хамгаалах, нөгөө нь хот хүрээг шилжүүлэх юм. Бодож үзвэл, дайтаж хамгаалах байнгынх атал, хот хүрээ шилжүүлэх нь түр зуурын арга билээ. Гэхдээ хаан та буянтай бол түр зуурын арга боломжтой боловч, буянгүй учир сайшаан зөвшөөх хүн байхгүй болов уу. Ард олон нэг тарж бутарвал дахин нэгдэх бэрх. Их хүч нэг харивал эргэх нь үгүй. Хаан та энэ хэргийг дайтан хамгаалж шийдэж бат сэтгэлээр хэлбэрэлгүй гүйцэлдүүлбэл бүх ард олон урам бадрах учир... хаан та одоо үтэр зарлиг буулгаж, дайтан хамгаалах учир шалтгааныг тайлан хэлсүгэй..."¹ гэжээ.

Энэхүү айлтгал бичигт Хуа Со-гийн эх орондоо зовних сэтгэл тод тусгалаа олжээ. Хуа Со-гийн айлтгал бичиг өрнийн дайсны араншин чухамхүү аюул тулгарсан бэрх үеийн ухамсраас эхтэй бөгөөд, урьдын уламжлал, ёс журмыг хадгалж чадахгүй учир хүн төрөлхтөн адгуус болж доройтох золгүй явдал болж мэдэхээс үүдэлтэй сэтгэл билээ. Энд "Хааныг эцэг шигээ хайрлаж", "Улсдаа гэр мэт санаж зовинох" хаанд үнэнч түмэн олондоо хайртай сэтгэл оюуны нэгдэл болж байна.

Хуа Со өрнийн хүмүүс соёлын довтолголт, эдийн засгийн түрэмгийлэлд амжилт олохгүй байх буюу амжилт оллоо ч гэсэн эцэстээ зэвсгийн хүч хэрэглэж нутаг орныг булаан эзлэх учир улсаа гэсэн сэтгэлийг учиртай батжуулах хэрэгтэйг онцолсон. Хуа Со "Сандунбү Сөнжи Гём Жинсу Хвэсу"-д бэрх байдлаас гарах аргыг санал болгосон бөгөөд эндээс тэрээр цэргийн хүмүүсийн сонгох, дасгал сургуулилтаар зэвсгийн хүчийг сайжруулах санал дэвшүүлж, Хар луу жилийн Японы эсрэг дайн болон Юүл Гүг И И-гийн урьдаар бэлтгэх үзлийн түүхийг сөхөж, "Арван түмэн сайн цэрэг" аргыг хэлжээ. Өөрөөр хэлбэл, найман аймагт тус тус нэг түмэн цэрэг, Сөүлд хоёр түмэн цэргийн хүчийг байнгын биш тариачны буюу бэлтгэл цэргээр нуугдуулж, аюулд урьдчилан бэлтгэлтэй байх хэрэгтэй гэсэн. Мөн ардын цэргийн тогтолцоогоор аймаг болгонд хүсэл бүхий нэг хүнийг уриалагчаар тохоож, түүний дор хоёр хүнийг уриалагч болгон тэднээр нутаг бүхний үнэн, журам, зориг, сахил бүхий хүнийг цуглуулж, журамт цэргийг бүрдүүлэн харийн дайсан халдан довтолбол төрийн цэрэгтэй хамтарч эх нутгаа

¹ И Хан Ну Хуа Со-гийн бүрэн эмхтгэл. 1986. 85-86 дахь тал

хамгаалах үүрэг гүйцэтгэж, энгийн үед хүний ёсонд боловсорч буруу номлолыг дарахад хүчин зүтгүүлэх хэрэгтэй хэмээх чухал үзэл санааг дэвшүүлжээ.

Мөн Хуа Со далайгаар довтлох харийн дайснаас хамгаалах аргыг санал болгосон. Тэрээр цайз хэрмийг байгуулж, бат сайн түгжиж, талбайг цэвэр байлган шуудууг гүн ухаж, дайсны халдлагыг урьдчилан таньж мэдэхүйцээр алс далайд хүртэл харуул манаа гаргахыг зөвлөсөн. Тэгээд тэрээр тал хээрийг энгийн үед цэргийн хуаран, сургуулилтын талбай болгож ашиглах ёстой гэсэн буй.

Хуа Со-гийн үзлээр, ард олон бол улсын үндэс, эх орноо батлан хамгаалах эх булаг гэдэг ухамсартай байж, улсын хаан уриалж, манлайлан үлгэр үзүүлж, хаан түшмэл, харц, дээдэс ялгалгүй сэтгэл нэгдэж, аливаа хэлбэрдлээс ангижирч, цэвэр төр байгуулж, үл итгэх хандлагыг бүрэн устгах ёстой. Мөн тэр ард олны зохицуулалтанд итгэж дэмжих эв эеийг хичээх нь зүйтэй. Тэгж чадсан цагт ямар ч харийн дайсныг хориглон няцааж чадна. Энэ бол Хуа Со-гийн санал болгосон дотоодоо тохинуулж, харийг үл халдаах үзлийн хураангуй юм.

Хуа Со нь Сүй улсын Ян Жэ Гугерёг үй түмээрээ довтлоход Өлжи Мүндог дайсныг няцаан дарж, Тан улсын үеийн Тэжун хааны сүр сүлд Ёнюн тэнгэрийн дор дайсангүй нэгэн байсан боловч Анши цайзын тулалдаан ялагдаж, Гурёгийн эцэс үеийн 200 мянга орчим улаан алчуурт дээрэмчнийг Тэжу (М Сон Гэ) бут цохисон түүхийг жишээлж, бид бас идэвхтэй байж улсын эвийг хичээж дайсантай тулбал өрнийн дайсныг дарж, ялалт байгуулж чадна гэж бат итгэсэн байна.

Энэ бүхэн нь харь үндэстний халдан довтлолыг эсэргүүцэж ирсэн Солонгос үндэстний түүхэн ухамсрыг онцолсон юм. Бодитоор энэ мэт Хуа Со-гийн үзэл Жусоны төрд биелэлээ олж улсын бодлогод тооцогдож, үүнийг дагаж Хуа Со-гийн бичгийн хүн Ян Хон Сү-гээр журамт цэргийг удирдуулж, Францын хөлөг онгоцыг бут цохин амжилт байгуулсан юм. Хуа Со-гийн улсыг батлан хамгаалах дээрх үзлүүд Солонгос үндэстний түүхэн ухамсарт суурилсан өөрөө оршихын төлөөх бие даан өөрийгөө хамгаалах оюун санаа гэж дүгнэж болох юм.

Дотоодоо тохинуулах үзэл ба үндэсний ухамсрын асуудал.

Түрэмгийллийг эсэргүүцэх бэлтгэлтэй байя гэвэл юуны өмнө төр засагдах ёстой гэсэн Дотоодоо тохинуулах үзлийн гол цөм нь үндэсний улс төрийн ухамсарт байсан юм. Хуа Со улс орныг хамгаалахад ард олныг амгалан болгох хамгийн чухал бөгөөд ард олныг амгалан болгоход төрийн санг хангалттай байлгах хамгаас чухал¹ гэж үзсэн. Энэ нь улсын ажил хэрэгт ард олны амьдралын амгалан тогтвортой байдал, айж сандрах зүйлгүй байх шиг чухал зүйлгүй гэсэн үг юм. Ард олон бодитоор улсын нийгмийн чухал даалгавар болох эдийн засаг, улсыг батлан хамгаалахын эх булаг бөгөөд зарчмын хувьд хааныг тэнгэр гэж үздэг тул ямар ч тохиолдолд ард олныг тэргүүнд тавих ёстой гэсэн үг.

¹ И Хан Ну Хуа Со-гийн эмхтгэл. Тэ Янь хэвлэлийн газар. 1975. 282 дахь тал

Тийм учраас ард олны төлөө байна гэдэг нь улсын бүх олон нийтийн үйл хэргийн тэргүүн зорилт төдийгүй, хаанаас эхлээд төрийн сайд түшмэлүүд, сэхээтэнд тооцогдох хүмүүсийн үүрэг байх ёстой. Хаан ард олноо элбэрэл ачлалт эцэг эх, үр хүүхдээ хайрлах мэт хайрлаж, нийгмийн сэхээтэн давхарга ард олныг хүсэл тэмүүлэлдээ багтаах ёстой гэсэн үг болно. Мэнз улс оронд "Ард олон хамгийн нандин, газар нутаг удаах нь, хаан түүний дараах чухал эрдэнэ" хэмээн үзсэн². Хуа Со Мэнзийн энэхүү ард олны төлөөх үзэл санааг жишээ болгож, *улсын эх үндэс бол ард олон болохыг хэлсэн нь чухал ардчилсан үзэл санааны нэг илрэл мөн Энэ талаар Хуа Со өгүүлэхдээ: "Мэнзийн сэтгэлд гагцхүү "ард олон" гэдэг үг л хадгалаатай байж сэтгэлээ нээхдээ хүртэл ард олныг ярьж, төрийн хэргийг хэлэлцэхдээ ч заавал ард олныг дурдаж, хаанд айлтгах буюу энгийн иргэнд заахдаа ч ард олныг ярьж байсан учир, ухаан билэгт хөөрхий сэтгэл бүх ард олонд байгааг чухалчилсан билээ"*¹ гэжээ.

Түүнчлэн Хуа Со-гийн үзлээр, *тэнгэр харна гэдэг нь чухам ард олон харна, тэнгэр сонсоно гэдэг нь ард олон сонсоно гэсэн үг. Ард олон яаралтайд тооцвол тэнгэр бас яаралтайд тооцож, ард олон аюултайд тооцвол тэнгэр бас аюултайд тооцно*. Харин Хуа Со эдүгээ хүмүүс энэ зарчмыг ухаарч чадалгүй ардын сэтгэлийг ухаж ойлгохгүй байна гэж харуусчээ.

Хуа Со-гийн энэ бодол тэнгэрийн тааллыг дагах болон түүнээс урвах нь энгийн олны баяр баясал, гуниг уйтгараар нотлогдож, ард олны амгалан байдал, түгшүүр тэргүүн хүмүүсийн цэвэр ариун болон шунаг сэтгэлээс шалтгаална.

Эцсийн дүнд ард олны зовлон жаргал хааны нэгэн сэтгэлээс хамаарах учир хаан буяныг гээлгүй бүхнийг манлайлж, ард олны үлгэр дууриал болж, *ямагт ард олныг бодол оюундаа тээх ёстой* хэмээн үзжээ. Ийнхүү Хуа Со тэнгэр нэг учир хаан тэнгэрийн ёсыг дагаж, төрийг барих ёстой бөгөөд ардын сэтгэлийг идэвхтэйгээр хүлээн авч тэднийг гэсэн сэтгэлээр төр барих ёстойг онцолсон байна.

Мөн Хуа Со *ард олны амьдрал улс орны хамгийн том харгалзах зүйл* гэж үзээд, ард амьдралыг зовоож, зүдрээж, улсын сан хөрөнгөөс зулгааж байгаа үндсэн шалтгаан нь дээд тушаалт сайд түшмэдийн сувдаг сэтгэлд бий гэжээ. Тэгээд улсын хаанаас эхлээд удирдах анги давхрага өөрсдөө үүнийг ухаарч арвиг хямгаж байж, төрийг удирдах нь зүйтэй хэмээн тэрээр үзсэн. Бас баялгийн тэнцвэртэй хуваарийг үл тоомсорлосноос үндсэн өөрөө оршихуй нь заналхийлэлд өртсөн энгийн иргэд аврагдах ёстой гээд, үүнд үндэслэн ардын хүчийг тэтгэх нь улс орныг аврах зам гэж үзсэн. Тийм учраас Хуа Со дараах саналыг гаргаж байжээ. Үүнд:

1. Хэрээс хэтэрсэн зардлыг бүрэн хориглох;
2. Ард олны зүтгэлийн үрийг дайчлахыг даруй зогсоох;
3. Цэрэг тариачныг тааруулах;

² Сон Бэг Хю "Хөрвүүлэг тайлбар: Мэнзийн эмхэтгэлийн тайлбар" Уламжлалт ёсны судалгааны нийгэмлэг. 1999. 27 дахь тал

¹ Сон Бэг Хю "Хөрвүүлэг тайлбар: Мэнзийн эмхэтгэлийн тайлбар" Уламжлалт ёсны судалгааны нийгэмлэг. 1999. 205 дахь тал

4. Шунаг бохир тушаалтныг хөөн зайлуулах;
5. Улсын хаан болон хааны ордноос эхлээд арвич хямгаж байх үлгэр жишээг үзүүлэх ёстой гэжээ.

Энд тухайн үеийн ард олон үгүйрэн доройтоод байсан нийгмийн дүр төрх сайтар тусгагджээ. Энэ арга бодлогонд хүчний төрийн замбараагүй байдал, ялзрал завхрал, нүсэр зарлага, төрийнхний доройтол, газар бүрийн ард олны бослого үймээн зэрэг ороогдон байсан улсыг тайлж суллахын тулд бодит байдалд буурь суурьтай дүгнэлт өгөх хэрэгтэй байсан гэдгийг мартаж болохгүй.

Цаашлаад өрнийн дайсан дур зоргоор аашилж хэцүү байдалтай нүүр тулсан цаг үеийг сэргээхийн төлөө арга зам болгож, Хуа Со дараах зүйлийг дурдсан айлтгал өргөжээ. Үүнд:

1. Зам барилгын ажлыг даруй зогсоох;
2. Шууд зарлигийг хүлээн авч хүн хүчний асуудлыг шийдэх;
3. Шагнал шийтгэлийн хууль цаазыг тодорхой болгох;
4. Хаан өөрөө манлайлж дайтах сэтгэлийг шулуутгаж, дайсныг дуудах болсон шалтгааныг бүрэн илчлэх;
5. Өрнийн сав суулгыг энгийн ард төдийгүй төрийнхөн ч хэрэглэхгүй байх;
6. Ардын урам зоригийг сэргээж тэмцэх сэтгэлийг өндөрсгөх эдгээр болно.

Энэ бичигт тухайн үеийн зам, барилгын ажил хааны эрх мэдлийг бий болгох зорилгоор 1865 оноос эхэлсэн Гёнбуг ордныг сэргээн засаж байсныг хэлжээ. Гёнбуг ордны засварт улсын сан төвлөрч илүү зарлагаар зогсохгүй, хүн хүч дайчлагдаж, ард олны гомдлын дуу хоолойны эх болж байв. Тийм учраас Хуа Со үүнийг нэн даруй зогсоо гэсэн байна. Түүнчлэн тэрээр өрнийн дайсныг зайлуулахад хаан өөрөө манлайлж, үлгэр үзүүлэн ард олны итгэлийг олж, өрнийг эсэргүүцэх оюун санааг өндөрт өргөх ёстой гэсэн бие даан дотоодоо тохинуулах үзлээ илэрхийлжээ. Харин төрд оролцогчид ямар ч гэм зэмгүй хүмүүсээр бүрэлдэх нь амаргүй учир ардын амгалан амьдралын төлөө тасралтгүй цэвэрлэгээ явагдаж байх ёстой гэсэн байдаг.

Хоёрдугаарт, харийн халдлагыг хориглохын төлөөх дотоодоо тохинуулах үзэл нь эдийн засгийн тэнцвэртэй ёсны ухамсар болоход түүний нэг онцлог оршино. Хувцас, хоол, байр бол хүний амьдралын үндсэн хүчин зүйл. Тийм учраас улс орон ард олныг сургахаас өмнө хувцас, хоол, байрны хамгийн наад захын хэрэгцээг шийдэх учиртай. Тэгэхийн тулд хүний амьдралын үндэс болсон газар нутгийг эрх тэгш хуваарилах ёстой. Үндсэндээ дээрх асуудлууд шийдэгдэж чадалгүй нүцгэн, өлсгөлөн ард түмэнд ёс журам, ёс суртахуун, хууль цааз, эмх цэгцийг ярьж хүсэх нь төрийнхний хэтэрсэн шунал л болж хоцорно.

Ямар ч эдийн засгийн үндэс бол газар нутаг. Хуа Со газар нутгийг тэнцүү хуваарилах тогтолцоо болгож "жонжонь (тариалангийн есөн талбайн дундахыг төрд бүрэн хэрэглэх)" тогтолцоог хамгийн тохиромжтой гэж үзжээ. Хэрвээ хүн амд харьцуулахад газар нутаг дутмаг байгаа тохиолдолд багаар ч болов тэнцүү хуваарилбал ядуу зүдүүг гэтэлгэж чадах бөгөөд улсын сангийн татварын орлого бага байлаа ч гэсэн арвилж хямгадвал болзошгүй

аюулын үед бэлтгэлтэй байхад төдийлөн саадгүй гэж үзсэн байна. Тиймээс Хуа Со улсын үндэс болсон ардын амьдралыг шийдэхийн тулд эдийн засгийн үндэс суурь болох газар нутгийг тэнцүү хуваарилах ёстой гэжээ. Хуа Со Жусоны хүн амын дийлэнхийг эзэлж байгаа худалдаачны давхаргад багтах хүмүүс ядуурал, мөлжлөгт зовж шаналж байхад, ноёд язгууртны давхарга элбэг дэлбэг эдийн амьдралд эргэж хөрвөж байх нь зүйд нийцэхгүй хэмээн үзсэн.

Бас түрээсийн газарт тариалан эрхлэгчийн дарамт ачаа хүнд, газрыг хавсран эзэмших зэргээс болж өөрт байснаа бүгдийг алдаж ард олны ачаа хэд дахин хүндэрч насан турш өлөн зэлмүүн амьдарч байгааг шүүмжилсэн. Хуа Со тариачин ардын талд зогсож буруу булхайг бүрэн үгүй хийхийн төлөө байв. Тиймээс Хуа Со газар бол тариачин хүнд ч хуваарилагдах ёстой, ургацын нэг хувийг давсан ямар ч төрлийн зарлага зүйд таарахгүй. Өөрөөр хэлбэл, тэрээр байр суурь зэрэг тушаалыг дагасан эдийн засгийн онцгой эрх шударга биш гээд тариачны талд зогсож баялгийг тэнцүү хуваарилахыг хэлж ярьж байв.

Хуа Со ургац муутай жил ард олон асар эмгэнэлт байдалд орж байгааг хэлэхдээ нүднээсээ нулимс хүртэл унагадаг байсан гэдэг. Тэрээр гарч орохдоо амрах газар болгонд заавал тухайн нутаг усны хүмүүсийн амьдралыг асууж, уршиг балаг байгааг дуулбал гуниглан тэр нутгийг орхиж түвддэггүй байжээ. Бас тэрээр тосгонд хоол хүнс байхгүйгээс тариалан тааруухан болохыг ичгүүртэйд тооцож, тарианы агуулах байгуулж тэднийг аварч байсан бөгөөд төрөөс албадах ажил ойр ойрхон болж олширсноос ийш тийш зарагдан нүүх өрх байвал тэдний оронд мөнгө төлж тусалдаг байжээ. Мөн Хуа Со ядуусын эцгийн нь үлдээсэн төрөл бүрийн өрийн бичгийг бүгдийг шатааж, гэрийнхэн нь хүч хүрэх хэмжээнийхээс илүү газрыг хөрш ядуу иргэдэд тарааж өгдөг байжээ.

Хуа Со-гийн ард олныг гэсэн ухамсар нийгмийн үзэл санаанд бас тусгалаа олсон. Тиймээс тэрээр тариа будаа хураах болгонд тодорхой хэмжээний ургацыг тусгайлан бэлдсэн агуулахад хадгалж байгаад хөрш ядууст өгөх буюу хурим найр, үхэл хагацал, гамшиг зовлон, өвчин эмгэг зэрэг олон түмэнд тус хүргэж байжээ. Түүнчлэн олон арван шуудай үр тариаг гаргаж ургац муутай жилд бэлдэн агуулах саванд хадгалуулж, цэргийн хэрэгцээний бөс даавууг хангахаас болж амьжиргаа хэцүүдсэн айл гэрийг аврахын тул "гэ" буюу хамтран мөнгө хуримтлуулах нэгдлийг хүртэл байгуулж байжээ. Хуа Со-гийн эдийн засгийн үзэл санаа эдийн засгийн эс болсон газрыг шударгаар хуваарилж, улсын ард иргэдийн амьдралын чанарыг тэнцвэржүүлэхэд чиглэгдэж байв. Хуа Со-гийн энэхүү бодол үндэсний ухамсарт үндэслэсэн эдийн засгийн эрх тэгш ёс гэж дүгнэж болно.

Гуравдугаарт, халдлагаас хамгаалахын төлөөх дотоодоо тохинуулах Хуа Со-гийн үзлийн өөр нэг онцлог нь нийгмийн эрх тэгш ёсонд үндэслэж байгаад оршино. Жусоны эцэс үе бол ноён язгууртны нийгэм хэвээр байсан. Хуа Со сурвалжит гэр бүлд өссөн боловч түүний үзэл санаа нийгмийн бүхэлд эрх тэгш ёсыг барьсан. Бүр цаашлаад тэрээр төрийн албанд хүнийг авахдаа нэг ч болов сайн тал байвал тэр чадварыг нь үнэлж авч хэрэглэх ёстой гэжээ. Энэ бол өнөөгийн үйлдвэрлэлийн бас хөдөлмөрийн хуваарь

гэгддэг орчин үеийн үйлдвэрийн нийгмийн ажлын онцлогоос шалтгаалж хүнийг боловсруулж, мэргэшүүлж, чадваржуулах сургалттай дүйнэ гэж үзүүштэй.

Бас балмад эсэргүү дайсан юм уу, хорон мөчид санаатны үр ачийг хэрэглэлгүй мөнхөд хаях ямар вэ? гэж асуухад “Аливаа хүнийг харж гэм буруутай бол шийтгэж, алдаа эндлийг засвал больдог. Тэр тусмаа үр ач нарт нялзаах учиргүй” гээд гэм бурууг шийтгэх нь тухай хүнээр л дуусна уу гэхээс гэр бүл, үр хүүхдэд нь түүнийг нялзааж болохгүй гэсэн чухал санаа юм. Энэхүү сэтгэлгээ гэмт хэргийн талаарх “ёнжважэ (гэмийг нялзаах тогтолцоо)” хэрэгжүүлж байсан тухайн үеийн хувьд авч үзэхэд нэлээд дэвшилттэй байсан нь тод бөгөөд ард олноо гэсэн үзэл санаа мөн гэж үзэж болно.

Хэн нэгэн хүн Хуа Со-д татвар эмийн хүүхдийг албанд тохоож тодорхойлох зүйд таарахгүй гэж хэлэхэд тэрээр, “Энэрэлт хүнийг сонгож хэрэглэвэл захирагдана. Тэгэхгүй бол үймээн самуун л нэмэгдэх болно” гэж хэлжээ. Тэгээд татвар эмийн үр хойчийг дорд үзэж харьцах нь Гурё улсын эцэст бараг л хатад (Юань улсын гүнж нар)-ын атаа жөтөөнөөс эхтэй тогтолцоожсон нь ёсонд нийцэхгүй гэжээ. Хуа Со ариун хүний хүнийг хэрэглэх арга нь авьяас чадварыг харж хэрэглэдэг болохоор, болох нэгийг нь сорин хэрэглэвэл болно. Хэрэв тэгэхгүй бол хэт өрөөсгөл болж мэдэх тул эцэстээ хүнийг зөв танихыг байж, тэр хүний чадвар зүтгэлийг мэдэх бэрх болно. Тийм учир Хуа Со төрийг барихдаа ухаалаг хүнийг албанд авч, чадварлаг хүнийг хэрэглэн, ухаалаг нэгнийг хэрэглэхдээ ялгаварлалгүй хандах нь чухал хэмээн үздэг.

Мөн түүнчлэн Хуа Со “Боловсролын хувьд төрийн шалгалт өгч болохгүй гээд эмэгтэй хүнийг эрдэм номноос хол байлгамгүй” гэжээ. Хуа Со хоёр охинтой байсан бөгөөд том охиноо бичгийн хүн Жан Хвэ Жин-тэй гэрлүүлэн, удаах охиноо бас бичгийн хүн Гим Жэ Гү-тэй гэрлүүлжээ. Жан Хвэ Жин бол ачлалт хүү байсан бөгөөд хорвоог эрт орхиж, бэлэвсэрч үлдсэн эхнэр нь түүнийг даган амиа егүүтгэх гэж оролджээ. Тэр эмэгтэй “Эмэгтэй хүний дөрвөн судар” номыг хуулбарлан бичиж, хэрэгжүүлсэн бөгөөд хадам эцэг эхээ сайтар асарч элбэрэлт бэр гэж нэрд гарчээ. Тиймээс Күнзийг дагагчид нэг нэгнээсээ өрсөлдөн тэр эмэгтэйн төлөө элбэрэлийн хөшөө, дурсгалын хөшөөг босгосон билээ. Удаах охин нь бичгийн хүний хувьд “Дөрвөн судар” номыг сурч, өөрөө бас бүтээл туурвил үлдээсэн. Түүний ханз бичиг биш цэвэр солонгос бичгээр бичсэн захиа бас байдаг. Үүнээс үзэхэд Хуа Со хичээл заахдаа хоёр охиноо хүүгээс ялгаагүй ажээ. Мэдээж хэрэг, бичиг номын өргөөнд сургаж заахдаа ч гэсэн хөгшин залуу, ихэс доодос, төрийнхний ялгавар, Күнзийн сургаал ба буддын шашны ялгаваргүй суръя гэсэн бүхнийг хүлээн авч байсан юм.

Хуа Со ялангуяа төрийнхний гажуудлын хор уршгийг хүлцээгүй. Тиймд тал бүлэг байхгүй сургамжийг хувирч өөрчлөгдөхгүй жам гээд бүлэгд захирагдаж зөвийг буруу гэхийг дэндүү туйлширсан хэрэг гэж шүүмжилсэн. Гэвч тэрээр улам илүү шүүмжилсэн нь зөв бурууг ялгалгүй аль аль нь зөв гээд өнгөрөөгч бөөрөнхий үзэлтнүүд байв. Хуа Со хорвоогийн хүнтэй нөхөрлөхдөө ялгаварлалгүйгээр шавь оруулж байсныг үзвэл, тухайн цаг үед

таарч зохицомгүй гэмээр дэвшилттэй үзэлтэн байжээ. Энэ нь түүний үзэл санаа эвсэг, оновчтой байснаар зогсохгүй, хүний эрх тэгш байх үзэл санаанд үндэслэсэн учраас боломжтой байв.

Хуа Со Мэнзийн сэтгэлд "ард олон" гэдэг хоёр үг л байдаг гээд, ард олныг хаан хүн тэнгэр мэт үзэж харьцах учиртай гэжээ. Ардын сэтгэл тэнгэрийн таалал гэж хэлсэн шиг Хуа Со-гийн нийгмийн үзэл санаа улс ба ардыг давж гарсан ёс зүйчийн хувьд түгээмэл шинжтэй хүн ёсны хайрын оюун сэтгэлд суурилжээ гэж үзэж байна. Хуа Со-гийн чухам энэ үзэл санаа нь дотоодоо тохинуулахын үндэс болсон билээ.

Мөн Хуа Со дотоодыг тохинуулж, харийг үл халдаахын харилцааг хэлэхдээ энэ хоёрыг зүйрлэвэл нэг модны үндэс, навч харилцан хэрэгтэй байдгийн адил алийг нь ч орхигдуулж болохгүй нь ойлгомжтой. Гагцхүү мөчир навч ч гэсэн хэдий ойртуулж болохгүй ч үндэс нь улам яаралтай билээ"¹ гэж онцлон хэлсэн. Ийнхүү Хуа Со-гийн дотоодыг тохинуулж, харийг үл халдаах үзэл нь ёс зүйн ухааны журмын үзэл санаан болох чогса вижон үзэлд үндэслэсэн. Гэхдээ Хуа Со-гийн дотоодыг тохинуулж харийг үл халдаах үзэл зүгээр нэг ёс зүйн ухааны бодит хэрэгжүүлэлт гэсэн утга төдий биш юм. Яагаад гэвэл, энэхүү дотоодыг тохинуулж, харийг үл халдаах үзэл эхнээсээ аваад дуустал бодит байдлын ухамсрын дор Солонгос үндэстний төрийн бие даасан эрх, эдийн засгийн тусгаар тогтнол, оюун санаа, соёлын үндэстний ухамсар, цэргийн өөрийгөө хамгаалах гэсэн үндэстний өөрөө бие даан оршихын төлөөх тэмцэл хөдөлгөөний удирдамж, тодорхой арга замыг зааж, бодит үр дүнд хүргэсэн түүхтэй юм.

Ном зүй:

1. И Хан Ну (Хуа Со)-гийн эмхтгэл. Тэ Янь хэвлэлийн газар. 1975
 2. И Хан Ну (Хуа Со)-гийн бүрэн эмхтгэл. Сөүл. 1975
- Сон Бэг Хю "Мэнзийн эмхэтгэлийн тайлбар" Сөүл. 1999

¹ И Хан Ну Хуа Со-гийн бүрэн эмхтгэл. 1986. 91 дэх тал